

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1.	Аудитын гэрчилгээ	2
2.	Аудитын тайлан	4
2.1.	Оршил	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8.	Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10.	Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12.	Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13.	Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14.	Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3.	Менежментийн захидал.....	10
4.	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	14
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	15
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	19
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	20
4.6	Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	22
5.	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	23

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.02.24 № 06/583
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дотоод хэргийн их сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дотоод хэргийн их сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дотоод хэргийн их сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ ДОКТОР (PH.D)
ПРОФЕССОР ХОШУУЧ ГЕНЕРАЛ
Ш.ЛХАЧИНЖАВ ТАНАА

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Дотоод хэргийн их сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус сургуулийн захирал, доктор (ph.d) профессор хошууч генерал Ш.Лхачинжав Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн орлогыг бодитой төлөвлөх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж бүртгэлд тусгахгүй байх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дотоод хэргийн их сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дотоод хэргийн их сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 24-нөөс 2020 оны 02 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор Д.Цэгмиддорж хариуцаж хэрэгжүүлэв.

Дотоод хэргийн их сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/131 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дотоод хэргийн их сургууль нь Хууль зүй, дотоод хэргийн яамны бодлого, дээд газрын тогтоол, шийдвэр, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Хууль зүйн сайдын 2016 оны А/119 дүгээр тушаалаар баталсан “Их сургуулийн хөгжлийн стратеги хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаагаа төлөвлөн, 2019 онд 3 зорилтыг дэвшүүлсэн байна. Үүнд:

“Сургалт, судалгааг хослуулах замаар шинжлэх ухаан, практик, боловсролын нэгдлийг ханган, багш суралцагчийг бүх талаар хөгжүүлж, үндэсний өрсөлдөх чадвараа дээшлүүлнэ” гэсэн зорилтыг дэвшүүлж амжилттай хэрэгжүүлсэн байна. “Хамтдаа бүтээе, бүгдээрээ хөгжье, хөгжилд тэмүүлье” уриа дэвшүүлж ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг дараах хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт орсон байна. Үүнд:

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 152 дугаар тогтоолоор Хууль сахиулахын их сургуулийн нэрийг Дотоод хэргийн их сургууль болгон өөрчлөн зохион байгуулж, улсын бүртгэлийн гэрчилгээг шинээр гаргуулан, тамга, тэмдгийг шинээр хийлгэж, Их сургуулийн дүрэм, бүтцийг боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны А/126 дугаар тушаалаар батлуулсан.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлоготой нийцсэн ч, холбогдох стандарт, хууль тогтоомжийн зарим заалтуудтай нийцэхгүй байна.

Дотоод хэргийн их сургууль нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа “ACOLOUS” программ хангамж ашигладаг байна.

Дотоод хэргийн их сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дотоод хэргийн их сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 13 эрсдэлтэй асуудалд 13 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 13,485,481.5 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 269,709.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээс 2 хувиар тооцож 313,660.8 мянган төгрөгөөр тодорхойлов.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дотоод хэргийн их сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 689,962.3 мянган төгрөгөөр буюу 1.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	1,393.7	1,393.7
Авлага	27,932.4	38,855.3	10,922.9
Урьдчилгаа	67,528.8	47,230.9	20,297.9
Бараа материал	2,284,388.1	21,54,496.2	129,891.9
Үндсэн хөрөнгө	66,317,275.0	67,145,110.5	827,835.5
Нийт хөрөнгө	68,697,124.4	69,387,086.7	689,962.3
Өр төлбөр	0	1393.7	1,393.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	68,697,124.4	69,385,693.0	688,568.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	68,697,124.4	69,387,086.7	689,962.3

Санхүүгийн тайлангаарх хөрөнгө, өр төлбөрийн өсөлт нь дараах шалтгаантай байна. Тухайлбал:

Авлага дансны үлдэгдэл нэмэгдсэн нь тайлант онд шинээр Нийгмийн даатгалын шимтгэлийн 10,922.9 мянган төгрөгийн авлага үүссэнтэй холбоотой байна. Авлага дансанд МООМ ХХК-тай холбоотой 2013 онд үүссэн сонсогчдын дотуур байранд хэрэглэгдэх орны бүтээлэг шаардлага хангаагүй, гэрээнд заасан хугацаанд нийлүүлээгүйгээс шүүхэд шилжүүлсэн 10,250.0 мянган төгрөг, иргэнтэй холбоотой 2003 онд үүссэн Шүүхийн байгууллагад шилжүүлсэн барагдах боломжгүй, найдваргүй болсон 17,682.4 мянган төгрөгийн авлагууд байна.

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 20,297.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь “Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай” хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-д заасны дагуу ажилтнууд нарт 18 сарын нэг удаагийн тэтгэмжийн урьдчилгаанд 47,230.9 мянган төгрөг олгосноос шалтгаалсан байна.

Дотоод хэргийн их сургуулийн захирлын 2019 оны “Эргэлтийн хөрөнгө акталж данснаас хасах тухай” А/19 дугаар тушаалаар 141,154.3 мянган төгрөгийн хөрөнгө, материалыг акталсан байна.

Дотоод хэргийн их сургуулийн захирлын 2019 оны “Хөрөнгө данс бүртгэлд бүртгэх тухай” А/130 дугаар тушаалаар 77,961.7 мянган төгрөгийн хөрөнгө, материалыг орлогод авсан байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 827,835.5 мянган төгрөгөөр өссөн нь Батлан хамгаалах сайдын 2018 оны А/343 дугаар тушаалаар сургуулийн сургалтын хэрэгцээнд Зил-131 загварын 16,100.0 мянган төгрөгийн 4 ширхэг ачааны автомашин, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 53 дугаар тогтоолоор “Засгийн газрын автобааз” улсын төсөвт үйлдвэрийн газраас 154,000.0 мянган төгрөгийн өртөгтэй Ланд

крузер 200 маркийн суудлын автомашин 1 ширхэгийг тус тус балансаас балансад шилжүүлэн, хандив, тусламжийн хүрээнд бий болсон 118,039.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод авснаас шалтгаалсан байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Үндсэн хөрөнгө, акталж устгах, данснаас хасах тухай” 94 дугаар тогтоолын дагуу 1,037,742.2 мянга, А-2/2487 дугаар тогтоолоор 86 нэр төрлийн 110,482.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг тус тус акталсан байна.

Эрх зүйн акт, тушаал, шийдвэрийн дагуу данснаас хассан болон шинээр авсан хөрөнгийг санхүүгийн тайлан, тодруулгад бүрэн хэмжээгээр тусгасан байна.

Урьдчилж орсон орлого дансанд оюутны зээл, эрсдэлийн сангийн үлдэгдэл 1,393.7 мянган төгрөгийг урьдчилж орсон орлогоор бүртгэж тайлагнасан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 69,385,693.0 мянган төгрөг болж тайлант үеийн үр дүнгээр 688,568.6 мянган төгрөгөөр өссөн байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Дотоод хэргийн их сургуулийн тайлант онд 14,940,273.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 14,940,237.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 100.4 хувиар биелүүлсэн байна.

Тайлант онд Дотоод хэргийн их сургуулийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрт зориулан 14,940,273.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 12,540,273.9 мянган төгрөгийг урсгал зардалд, 2,400,000.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагдсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 14,216,123.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагаанаас 790,836.4 мянган төгрөгийн орлого олж, нийт 15,006,960.3 мянган төгрөгийг бүрдүүлж, 14,938,843.5 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж улсын төсөвт 66,723.1 мянган төгрөг төвлөрүүлж, харилцах дансанд 1,393.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

“Спорт цогцолбор, номын сан”-гийн барилга угсралтын ажил гүйцэтгэх хөрөнгө оруулалтын 2,400,000.0 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсан. Билгүүн монгол констракшн ХХК-тай байгуулсан 2019 оны 2019/58 тоот гэрээгээр 2,400,000.0 мянган төгрөгийг зарцуулсан.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт төсөв:

Нийт 1,444,488.2 мянган төгрөгийг Төрийн болон төрийн бус байгууллага, боловсролыг дэмжих сан, төсөл арга хэмжээнээс их сургуульд дэмжлэг үзүүлэх зорилгоор олгосон санхүүжилтийг тухай бүр нь төрийн сангийн данс, нэмэлт дансаар дамжуулан зарцуулж, тайлагнасан. Тухайлбал:

- “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй мөрдөн байцаалт, прокурорын хяналтыг сайжруулах нь” төслийн хүрээнд Азийн сангаас 114,830.6 мянган төгрөг;
- “Адууны туурайн криминалистикийн адилтгал болон онол зүйн шинжилгээний объект болохыг тогтоох нь”, “Мөрдөн шалгах ажиллагаанд ашиглах криминалистикийн техник, хэрэгслийг боловсронгуй болгох туршилт судалгаа”-ны ажилд Шинжлэх ухаан, технологийн сангаас 58,162.5 мянган төгрөг;

- Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Эрдэм, шинжилгээ судалгааны ажилд 920,000.0 мянган төгрөг, сургалт, арга хэмжээний зардалд 66,568.0 мянган төгрөг, нийт 988,568.0 мянган сая төгрөг;
- Азийн хөгжлийн банкнаас гамшгийн эрсдэлийн үнэлгээний сургалт, арга хэмжээний зардалд 10,700.0 мянган төгрөг;
- Баянзүрх дүүргийн засаг даргын тамгын газраас шүүхийн шийдвэр гүйцэтгэх сургуульд компьютер, техник хэрэгсэл худалдан авахад 12,100.0 мянган төгрөг;
- Нэгдсэн үндэсний байгууллагаас зохион байгуулсан “хөгжлийн хөтөлбөр” сургалтын зардалд 37,200.0 мянган төгрөг;
- “Дээд боловсрол шинэчлэл төсөл”-ийн хүрээнд зохион байгуулсан сургалтын зардалд 13,100.0 мянган төгрөг;
- Сангийн сайдын 2019 оны “Улсын төсвийн байгууллагуудын үйл ажиллагааны давсан орлогыг зарцуулах тухай” 185, 251 дугаар тушаалын дагуу сургалтын төлбөрийн давсан орлогоос 170,891.1 мянган төгрөг;
- Сургалт, арга хэмжээ, тэмцээн уралдааны зардалд 38,900.0 мянган төгрөг;

Тайлант оны үйл ажиллагааны давсан орлого 170,891.1 мянган төгрөгийг Сангийн сайдын 2019 оны 185, 251 тоот тушаалын дагуу нэмэлт орлогоор бүртгэсэн байна. Үүнээс цалингийн зардалд 144,700.8 мянга, түлш халаалтын зардалд 26,190.3 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Дотоод хэргийн их сургуулийн “Төв номын сан-спорт цогцолбор”-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр “Билгүүн монгол констракшн” ХХК-ийг сонгон шалгаруулж барилгын ажлын явц 2019 оны 12 дугаар сарын байдлаар 60 хувийн гүйцэтгэлтэй байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 13 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд шинээр эрсдэл тодорхойлох шаардлагагүй гэж үзэж нийт 13 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 1,533,455.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 1,533,455.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өглөө.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд хамтран ажиллах тухай Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан 2018 оны 200, 201 дугаартай нийт 798,000.0 мянган төгрөгийн гэрээ, “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн биелэлтийг хангах хүрээнд хамтран ажиллах тухай Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан 2019 оны 177 дугаартай 122,000.0 мянган төгрөгийн гэрээний хэрэгжилтийг хянан шалгах шаардлагатай байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Дотоод хэргийн их сургууль 2019 онд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 175 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Нийт 4 зөвлөмж өгснөөс 4 зөвлөмжийг 100.0 хувьтай хэрэгжүүлсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дотоод хэргийн их сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дотоод хэргийн их сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Цалингийн данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Ажиллагсдын цалингаас үнэмлэхийн бэлдэц, үнэмлэх хэвлэх төхөөрөмжийн хор, голограммд 4,680.0 мянган төгрөгийг суутгасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэхгүй байх;

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, холбогдох хууль журмыг мөрдөж ажиллах;

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Онцгой байдлын ерөнхий газрын 2016 оны А/15 дугаар тушаалаар нийслэлийн Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтсийн гал түймэр унтраах аврах 14 дүгээр ангиас гал унтраах тусгай зориулалтын автомашин, үүргийн гал унтраагуур, үлээгч аппарат, хүрз зэрэг 4 нэр төрлийн 572,571.7 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг 2016 онд хүлээлгэн өгсөн байна. Дээрх хөрөнгө нь ямар нэгэн тогтоол шийдвэргүйгээр Дотоод хэргийн их сургуульд ашиглагдаж байна.

3.2.2. Эрсдэл:

Тооллого тооцоо бодит тоо, мэдээнд үндэслэхгүй байх;

3.2.3. Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3-т "Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно" гэж заасныг мөрдөж ажиллах;

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.3. Орлого данстай холбоотой асуудал

3.3.1. Илрүүлэлт:

Хууль сахиулахын их сургуулийн захирлын 2019 оны А/56 дугаар тушаал 2019-2020 оны хичээлийн жилийн бакалаврын элсэлтийн журам баталсан байна. Дээрх журмын Эрх зүйн хөтөлбөрт 60 элсэгч элсүүлэхээр баталсан боловч гүйцэтгэлээр 101 элсэгч авсан байна. Дээрх элсэгч нартай холбоотойгоор үндсэн үйл ажиллагааны орлого 36,021.2 мянган төгрөгөөр давж биелсэн байна. Батлагдсан төлөвлөгөөний дагуу элсэлт аваагүй, орлогын төлөвлөгөөг бодитой төлөвлөөгүй байна. Энэ нь Хууль сахиулахын их сургуулийн захирлын 2019 оны А/56 дугаар тушаал 2019-2020 оны хичээлийн жилийн бакалаврын элсэлтийн журмыг зөрчсөн байна.

3.3.2. Эрсдэл:

Орлогыг бодитой төлөвлөж, батлагдсан төлөвлөгөөний дагуу ажиллах, Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэхгүй байх, үйл ажиллагааны орлогыг бодитой төлөвлөхгүй байх;

3.3.3. Өгсөн зөвлөмж:

Хичээлийн жилийн бакалаврын элсэлтийн журмыг мөрдөж ажиллах, өмнөх онуудтай харьцуулж орлогыг бодитой тоон мэдээнд үндэслэж төлөвлөж байх;

3.3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.4. Зардал данстай холбоотой асуудал

3.4.1. Илрүүлэлт:

Мобиком корпораци ХХК-д гар утасны төлбөр болох 182.7 мянган төгрөгийг төлсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", УИХ-ын 47 дугаар тогтоолын 2-в-2-т "албан тушаалтны гар утасны зардлыг төсвөөс санхүүжүүлэхгүй байх" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

3.4.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэхгүй байх, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулах;

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, холбогдох хууль журмыг мөрдөж ажиллах;

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.5. Зардал данстай холбоотой асуудал

3.5.1 Илрүүлэлт:

Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд хамтран ажиллах тухай Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан 2018 оны 200, 201 дугаартай нийт 798,000.0 мянган төгрөгийн гэрээ, "Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-ийн биелэлтийг хангах хүрээнд хамтран ажиллах тухай Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан 2019 оны 177 дугаартай 122,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулсан байна. Дээрх гэрээтэй холбоотой гэрээ дүгнэсэн акт, протокол үйлдээгүй, гүйцэтгэлийн тайлан холбогдох баримт материал дутуу байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", "13.7-д Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

3.5.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэхгүй байх, ашиглан залилан үүсэх;

3.5.3 Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах, гэрээ ажил үйлчилгээг дүгнэж акт, тэмдэглэл үйлдэж байх, гэрээний хэрэгжих хугацааны биелэлтийг тооцож байх;

3.5.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.6. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

3.6.1 Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт хүчингүй болсон тушаал, шийдвэрийг шинэчлэх ажлыг хийгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

3.6.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, хүчин төгөлдөр хууль журамд үндэслэхгүй байх;

3.6.3 Өгсөн зөвлөмж:

УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох заавар, журам байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, батлуулан мөрдөж ажиллах;

3.6.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,379,849,380.21	2,241,976,228.24
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	1,393,680.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	1,393,680.00
31210	Төгрөг	-	1,393,680.00
31211	Төрийн сангийн харилцах	-	1,393,680.00
33	АВЛАГА	27,932,424.00	38,855,365.00
33500	Бусад авлага	27,932,424.00	38,855,365.00
33510	Байгууллагаас авах авлага	10,250,000.00	21,172,941.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	17,682,424.00	17,682,424.00
34	УРЬДЧИЛГАА	67,528,818.00	47,230,920.00
34600	Урьдчилж гарсан зардал	67,528,818.00	47,230,920.00
35	БАРАА МАТЕРИАЛ	2,284,388,138.21	2,154,496,263.24
35100	Түүхий эд материал	455,062,327.36	444,863,790.66
35110	Тусгай зориулалттай материал	444,111,451.06	440,973,863.06
35130	Эм боох материал	10,950,876.30	3,889,927.60
35300	Бэлэн бүтээгдэхүүн	549,753,985.51	675,823,566.90
